



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Төрийн орон сууцны корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1.Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 0/1140 дүгээр албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 05/7324 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Төрийн орон сууцны корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирлаар Баатарын Эрдэнэбулганыг холбогдох хууль тогтоомжийн дагуу түр томилж, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах.

2.“Төрийн орон сууцны корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг 2023 оны 2 дугаар улиралд багтаан зохих журмын дагуу зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Шинэхүү)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ